

Оюу толгойн Далд уурхайн бүтээн байгуулалтын Ханган нийлүүлэгчдийн форум

Монгол улс, Улаанбаатар хот



Оюу толгойн Далд уурхайн бүтээн байгуулалтын Ханган нийлүүлэгчдийн форумгаар “Оюу толгой” компанийн Ерөнхийлөгч бөгөөд Гүйцэтгэх ерөнхий захирлын хэлсэн үг

11 дүгээр сарын 4, 2015

Монгол улс, Улаанбаатар хот

Сайн байцгаана уу. Энд хүрэлцэн ирсэн эрхэмсэг хатагтай ноёд, хүндэт зочид та бүхэнд энэ өглөөний мэндийг хүргэе.

“Оюу толгойн далд уурхайн бүтээн байгуулалтын Ханган нийлүүлэгчдийн форум”-д та бүхнийг хүлээн авч байгаадаа миний бие таатай байна.

Өнөөдөр энд дэлхийн 29 орны 600 орчим компанийн төлөөлөгчид хүрэлцэн ирээд байгаа ба үүнээс 396 нь үндэсний аж ахуйн нэгжүүд байна.

Далд уурхайн бүтээн байгуулалтын энэхүү форум нь Оюу толгойн далд уурхайг хөгжүүлэхэд томоохон ахиц дэвшил авчрах чухал үйл явдал болж байна.

Та бүхэн өнөөдрийн форумд оролцсоноор энэхүү нарийн түвэгтэй, хүч сорьсон төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай зүйлсийн тухай, мөн энэ их ажлыг хэрхэн аюулгүй, үр ашигтайгаар гүйцэтгэж, оролцогч талуудад ирэх үнэ цэнийг нэмэгдүүлэх, Монгол Улсад бодит хувь нэмэр, үр өгөөж бий болгох тухай зохих ойлголттой болно гэж найдаж байна.

Далд уурхайн тухай ярихаасаа өмнө би энэхүү боломжийг ашиглаад компанийнхаа тухай, өнгөрсөн хугацаанд бид ямар амжилт гаргасан талаар, мөн алсын хараа, эрхэм зорилгынхоо тухай цухас дурдмаар байна.

Юуны түрүүнд манай компани бол Монгол компани.

Тиймээс бид эрхэм зорилгодоо “... дэлхийд өрсөлдөхүйц зэсийн үйлдвэрлэлийг цогцлоож, Монгол Улсын хөгжил дэвшилд хувь нэмэр оруулна” хэмээн тусгаж өгсөн байдаг.

Энэ нь бидний үйл ажиллагааныхаа бүхий л хэсгээс харагддаг. Тухайлбал:

- “Оюу толгой” компанийн нийт ажиллагсдын 95 хувийг Монгол ажилтнууд эзэлж байна.

- 2015 онд бид ойролцоогоор 885 ханган нийлүүлэгчидтэй хамтран ажилласан ба үүний 576 нь дотоодын ханган нийлүүлэгчид байна. Эдгээр аж ахуйн нэгжүүдийн ард нийт 35,000 гаруй ажилтан, тэдний гэр бүл байгаа юм.
- 2010 онд барилга угсралтын ажил эхэлснээс хойш ажилчдын цалин, дотоодын ханган нийлүүлэгчдийн төлбөр тооцоо, Монгол Улсын засгийн газарт төлсөн татвар, бусад төлбөр хураамж зэргээр дотоодод зарцуулсан мөнгөн хөрөнгийн хэмжээ 5.13 тэрбум ам.долларыг даваад байгаа нь Монгол Улсад бодит нөлөө үзүүлж байна.
- Аймаг, орон нутгийн ард иргэдтэй харилцаа, хамтын ажиллагаагаа улам баяжуулж, энэ оны “Хамтын ажиллагааны гэрээ” байгуулсан. Уг гэрээний дагуу нийгмийн хөгжил, дэд бүтцийн төслүүдэд жил бүр 5 сая ам.долларын хөрөнгө оруулахаар шийдвэрлэсэн.

Манай компани дэлхийн стандартыг хангасан, олон улсын түвшинд хүрсэн үйл ажиллагаа явуулдаг гэдгийг энд мөн тэмдэглэн хэлэх нь зүйтэй.

- Аюулгүй ажиллагааны хувьд манай компани сайн үзүүлэлттэй буюу салбарынхаа шилдгүүдийн эгнээнд хүрсэн үйл ажиллагаа явуулж байна.
- Байгаль орчны гүйцэтгэлийн хувьд бид сайн үзүүлэлттэй ажиллаж байгаа бөгөөд “Оюу толгой” компани нь усыг хамгийн үр ашигтай ашигладаг зэсийн уурхайнуудын нэг юм. Бид дэлхийн дунджаас хоёр дахин бага ус зарцуулдаг ба нийт ашигласан усныхаа 85 гаруй хувийг дахин ашигладаг.
- Өнгөрсөн 2 дугаар сард ОТ компани 1 сая дахь тонн баяжмалаа тээвэрлэсэн бол 9 дүгээр сард 1.5 сая дахь тонн баяжмалаа тээвэрлэлээ. Энэ үзүүлэлт нь үйлдвэрлэлээ эхлээд төдийлөн удаагүй компанийн хувьд хурдан өсч дэвшиж байгааг харуулж байна.
- Өнөөгийн зах зээлийн нөхцөлд манай компани бүтээмжийг нэмэгдүүлж, зардлыг бууруулах, урт хугацаанд тогтвортой үйл ажиллагаа явуулахад анхаарч ажиллаж байна.

Тийм ч учраас өнөөдөр бид тогтвортой, үр ашигтай ирээдүйг хамтдаа бүтээх зорилгоор энд хүрэлцэн ирээд байгаа билээ.

Оюу толгойн нийт үнэ цэнийн 80 гаруй хувь нь газрын гүнд орших бөгөөд далд уурхайн олборлолт явуулах нь компанийн урт хугацааны амжилттай шууд холбоотой.

Газрын гүн дэхь Оюу толгойн орд нь дэлхий дээрх хамгийн агуулга сайтай орд газруудын нэг мөн. Иймээс далд уурхайн олборлолт явуулснаар “Оюу толгой” компани нь ирээдүйд дэлхийн зэсийн зах зээл дээрх хамгийн чухал тоглогчдын нэг нь болох юм.

Бид далд уурхайн өндөр агуулгатай хүдрийг олборлож, үр ашигтайгаар боловсруулах замаар үнэ цэнийг бий болгохоор ажиллаж байна.

Далд уурхайн энэ том төслийг хэрэгжүүлэхэд тогтвортой хамтын ажиллагаа, түншлэл, хамтын хичээл зүтгэл нэн чухал.

Бид далд уурхайг ажиллууснаар газрын гадаргаас ойролцоогоор 1.3 км-ийн гүнд хүдэр олборлох юм.

Хүдрийн биетэд хүрэхийн тулд 200 км гаруй урт хөндлөн малталт хийж, нийт 6 км орчим урттай 5 ширхэг босоо амыг ашиглалтанд оруулах шаардлагатай.

Далд уурхайн бүтээн байгуулалтын ажилд хүн хүч ихээр шаардлагатай. Энэ ажилд ойролцоогоор 3000 орчим ажилчид хэрэгтэй болох ба тэдгээрийн ихэнхи нь Монголчууд байх юм.

Ил уурхай, Хойд Хюго ордын Ашиглалтын давхар 1 хоёр нийлээд 2050 он хүртэл ашиглах хүдрийн нөөцтэй гэж тооцоолсон. Бусад хүдрийн биетийг олборлох тохиолдолд уурхайг 2100 он гартал ашиглах боломжтой.

Бид одоогийн байдлаар жилд дунджаар 700,000 тонн баяжмал үйлдвэрлэж байгаа ба далд уурхайн үйлдвэрлэл бүрэн хүчин чадалдаа хүрэхэд жилд 1,800,000 тонн баяжмал үйлдвэрлэх тооцоолол бий.

Өөрөөр хэлбэл өнөөдөр бид жилд 180,000 тонн зэс агуулсан баяжмал үйлдвэрлэж байгаа бол далд уурхай бүрэн хүчин чадлаараа ажиллахад энэ тоо 600,000 тонн болж нэмэгдэх юм.

Энэхүү чухал өргөтгөлийн үйл ажиллагааны хүрээнд далд уурхайд шаардлагатай худалдан авалтыг Монголд төвлөрүүлж, удирдан чиглүүлнэ.

Та бүхэн Оюу толгой компанийн ирээдүй, компанийн оролцогч талууд, орон нутгийн өмнө хүлээсэн бидний үүрэг амлалт, далд уурхайг бүтээн байгуулахад юу шаардлагатай, тэдгээрийг хэрхэн хэрэгжүүлэх талаар дэлгэрэнгүй мэдээллийг бусад илтгэлээс авах болно.

Түүнчлэн энэхүү бүтээн байгуулалтын ажилд гар бие оролцох боломжийн талаар Оюу толгой, Рио Тинтогийн төлөөлөгчидтэй та бүхэн өнөөдөр ярилцах боломжтой.

Манай компани “Эрдэс баялгаас эрдэм мэдлэг, ур чадвар, үнэт зүйлс бүтээлцэнэ” гэсэн алсын хараатай ажилладаг.

Энэ цаг мөч нь бидний хувьд онцгой цаг мөч бөгөөд том боломж юм.

Бид хүн төрөлхтөнд ач тустай бизнесийн нэгэн хэсэг байж, олон жилийн турш дэлхий даяар ашиглагдах бүтээгдэхүүнийг олборлох боломж байна. Бидний бүтээгдэхүүн дэлхийн хамгийн алслагдмал газар нутгийг цахилгаан эрчим хүчинд холбохоос эхлээд анагаах ухаан, харилцаа холбооны технологийг дараагийн түвшинд аваачихад чухал үүрэг гүйцэтгэнэ.

Бидний хийж бүтээсэн ажил дэлхийн өнцөг булан бүрт хүрч, биднээс урт наслах болно.

Уул уурхайн салбар нь бизнесийн үйл ажиллагаа явуулахад тийм ч хялбар салбар биш.

Гэхдээ “Оюу толгой” компанийн үйл ажиллагаа өнөөдөр дэлхийн стандартад хүрээд байна.

Манай компанийн нийт хамт олон бат бэх, сайн суурь тавьж чадлаа.

Цаг зав гаргаж хүрэлцэн ирсэнд, мөн та бүхний урам зориг, хүсэл эрмэлзэлд талархсанаа илэрхийлэе.

Оюу толгойн дараагийн үе шатандаа орж буй энэ чухал цаг мөчид та бүхэн бидэнтэй нэгдэж, хамтран ажиллана гэдэгт итгэж байна.

Дэм дэмэндээ, дээс эрчиндээ гэсэн Монгол ардын үг бий. Анхаарал хандуулсанд баярлалаа.